



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 11/319

Улаанбаатар хот

Коронавируст халдварын үеийн хариу арга хэмжээний зураглал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 заалт, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинжилгээний бүртгэл хийх, лабораторид шинжлэх, хариуг оруулж эргэн мэдээлэх зураглал-I”-ыг нэгдүгээр, “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэг илэрсэн тохиолдлын хариу арга хэмжээний зураглал-II”-ыг хоёрдугаар, “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын мэдээ, эрэмбэлэн ангилалт, хяналт, эмчилгээний зураглал-III”-ыг гуравдугаар, “Эмнэлэгт хийгдэх коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, хяналт, эмчилгээний зураглал-IV”-ийг дөрөвдүгээр, “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын бүртгэл, мэдээллийн урсгалын зураглал-V”-ыг тавдугаар, “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн шуурхай хариу арга хэмжээний багийн зохион байгуулалтын зураглал-VI”-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Коронавируст халдварын үеийн хариу арга хэмжээний зураглалын дагуу шуурхай хариу арга хэмжээний зохион байгуулалт, КОВИД-19 халдварын илрүүлэг, бүртгэл мэдээлэл, эрэмбэлэн ангилалт, оношилгоо, хяналт, эмчилгээг хийхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төр, хувийн хэвшлийн бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Буянтогтох), Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан)-т тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД


• 141211454





Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 сарын 18 өдрийн дугаар тушаалын хоёрдугаар хавсралт


## КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРСЭН ТОХИОЛДЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГЛАЛ-II






Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 сарын 15 өдрийн дугаар тушаалын гуравдугаар хавсралт

### КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН БАТЛАГДСАН ТОХИОЛДЛЫН МЭДЭЭ, ЭРЭМБЭЛЭН АНГИЛАЛТ, ХЯНАЛТ, ЭМЧИЛГЭЭНИЙ ЗУРАГЛАЛ – III



Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 сарын 13  
 өдрийн дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ЭМНЭЛЭГТ ХИЙГДЭХ КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ОНОШИЛГОО, ХЯНАЛТ, ЭМЧИЛГЭЭНИЙ ЗУРАГЛАЛ-IV




АНХААРАХ: ЗҮЙЛ

1. Тандалтын системд эмнэлэгт хүлээн авсан бүртгэл хийх | 2. Өвчний түүхийг эмнэлгийн дотоод эмнэлгүүйн програмд хөтлөх | 3. "Эмнэлгийн цахим магадлагаа"-г үүсгэх



Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 сарын 18 өдрийн дугаар тушаалын тавдугаар хавсралт

## КОРОНАВИРУС Т ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН БАТЛАГДСАН ТОХИОЛДЛЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛЫН ЗУРАГЛАЛ-V





Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 сарын 18 өдрийн дугаар тушаалын зургаадугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕИЙН ШУУРХАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГЛАЛ – VI

